



I-IX/2023

Тархаасан: 2023 оны 10 дугаар сарын 10



Газар хөдлөлт 2023 оны эхний 9 сард 63 удаа бүртгэгджээ

Аюулт үзэгдэл, ослын тохиолдол 2023 оны эхний 9 сарын байдлаар 3234 болж, өмнөх оны мөн үеэс 70 (2.2%)-аар өссөн байна. Объектын түймэр 2023 оны эхний 9 сард 2188 удаа бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 93 (4.1%)-аар буурсан бол газар хөдлөлт 63 удаа бүртгэгдэж, 10 (18.9%)-аар өссөн байна.

Аюулт үзэгдэл, ослын улмаас 2023 оны эхний 9 сард нийт 247 хүн амь насаа алдаж, өмнөх оны мөн үеэс 31 (14.4%)-ээр өссөн байна.

ХҮСНЭГТ 1. АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ², жил бүрийн эхний 9 сарын байдлаар

Үзүүлэлт	2020 I-IX	2021 I-IX	2022 I-IX	2023 I-IX	2023 I-IX
					2022 I-IX
					хувь
Аюулт үзэгдэл, ослын тохиолдол	3 127	2 857	3 164	3 234	102.2
Үерийн тоо	64	72	21	107	5.1 ¹
Газар хөдлөлтийн тоо	44	277	53	63	118.9
Объектын түймрийн тоо	2 315	1 847	2 281	2 188	95.9
Амь насаа алдсан хүний тоо	208	269	216	247	114.4
Учирсан хохирол, тэрбум төгрөг	108.2	19.0	26.7	45.1	168.9
Зарцуулсан зардал, сая төгрөг	258.5	1 082.1	3 055.1	762.3	25.0

¹ Дахин их

² Корона вирус халдварын тохиолдлын тоо болон түүнтэй холбоотой гарсан зардлыг оруулаагүй.

Аюулт үзэгдэл, ослын улмаас 2023 оны эхний 9 сарын байдлаар 45.1 тэрбум төгрөгийн хохирол учирч, 0.8 тэрбум төгрөг зарцуулсан байна.

Ойлголт, тодорхойлолт

Аюулт үзэгдэл: Хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, аянга, газар хөдлөлт, гал түймэр, хүн, мал, амьтны гоц халдварт өвчин гарах, хортон шавж, мэрэгч тархах зэргийг хэлнэ.

Гамшиг: Аюулт үзэгдэл, ослын улмаас олон хүний амь нас, эрүүл мэнд хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд улс болон орон нутгийн эдийн засаг, нийгмийн дотоод нөөц, боломжоос давсан хохирол учрахыг хэлнэ.



Эх үүсвэр:

Онцгой байдлын ерөнхий газар

Мэдээлэл авах холбоос:

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2023 оны 11 дүгээр сарын 17

Эдийн засгийн статистикийн
газрын дарга М.Оюунжаргал
Утас : (976-11)-329271

Эдийн засгийн статистикийн
газрын ахлах статистикч Б.Уянгаа
Утас : (976-51)-261563

